

БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ
БАЙЦАГЧ ГАНХУЯГ ОВОГТОЙ ЭНХЖАРГАЛЫН 2024 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”								
1.	Арга хэмжээ 1.1. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам, зааврын шинэчилсэн төслийг боловсруулсан байна.	ГЕГ-ын даргын 2015 оны 135 болон 2022 оны 344 тоот тушаалаар тус тус батлагдсан “Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам” болон “Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх заавар”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн 2024.06.04-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, ГЕГ-ын даргын 2024.07.01-ний өдрийн А/395, А/396 тоот тушаалаар батлуулсан. Энэ ажлын хүрээнд 2024 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн: ■ Шинэчлэн найруулсан төсөлтэй холбоотойгоор ГЕГ-ын нийт 18 ЗББНДБ, гаалийн газар,	2024.01.01-2024.12.31	100	

				хорооноос ирүүлсэн саналыг нэгтгэж, саналыг нэгбүрчлэн газраараа хэлэлцэж, шийдвэрлэсэн; ■ Төсөлтэй холбоотойгоор ДТБ-ын экспертүүдээс ирүүлсэн 10 хуудас зөвлөмжийг орчуулж, газрын хамт олон танилцуулж, хэлэлцүүлсэн; ■ Журам, зааврын төслийг газрын хэмжээнд 2024 оны 02 дугаар сард 2 удаа, 03 дугаар сард 2 удаа, нийтдээ 4 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан; ■ Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журмын шинэчилсэн найруулгын төсөлд санал авахаар Дотоод зурвасаар Олон нийтэй харилцах албанд хандаж, 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Гаалийн байгууллагын цахим хуудаст байршуулсан; ■ Журам, зааврын шинэчилсэн найруулгын төслийг 2024 оны 04 дүгээр сар болон 05 дугаар сард нийтдээ 2 удаа Дотоод зурвасаар Хуулийн хэлтэст хүргүүлж, хянуулсан; ■ Журам, зааврын шинэчилсэн найруулгын төслийг Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, холбогдох танилцуулга (Word, Powerpoint)-	
--	--	--	--	---	--

				ыг бэлтгэж, Захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн. ■ Журам, заавар батлах тухай ГЕГ-ын даргын 2024.07.01-ний өдрийн А/395, А/396 тоот тушаалын төслийг бэлтгэж, батлуулсан; ■ Журмын шинэчилсэн найруулгын төслийн нөлөөллийн шинжилгээг хийж, 2024.07.03-ны өдөр Хууль зүйн яаманд хүргүүлж, хянуулан Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн сангийн 6900 дугаарт бүртгүүлсэн.		
--	--	--	--	--	--	--

Зорилт 2. "Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх"

1	Арга хэмжээ 2.1. Бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хийсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хийсэн байна.	Гаалийн ерөнхий газрын даргын баталсан 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 240603/0040 тоот удирдамжийн дагуу ХХК-д бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хийж, нийт 20.5 сая төгрөгийн нөхөн татвар, торгуулийг ногдуулж, төсөвт төвлөрүүлсэн.	2024.01.01-2024.12.31	100
2.	Арга хэмжээ 2.2. Төрийн болон хууль, байгууллагатай хамтран ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Төрийн болон хууль, хяналтын байгууллагатай хамтран ажилласан байна.	Тайлант хугацаанд дараах үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажилласан: ■ БДШ-ын үр дүнгээр захиргааны журмаар шалган шийдвэрлэсэн 7 зөрчлийн хэргийн материалыг НТГ-аар хянуулах ажиллагаа; ■ БДШ-ын үр дүнгээр илэрсэн гэмт хэргийн шинжтэй 1 зөрчлийг Цагдаагийн байгууллагад шилжүүлэх ажиллагаа.	2024.01.01-2024.12.31	-

3.	Арга хэмжээ 2.3. Нөхөн төлбөрийн барагдуулалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Нөхөн төлбөрийн авлагыг барагдуулсан байна.	Өмнөх оны өр, авлагыг барагдуулах чиглэлээр 1 ААН, байгууллагад холбогдох 150 сая төгрөгийн төлбөрийг гаргуулахаар Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 3 удаа хандаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудас гаргуулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллаж, тухайн асуудлыг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлсэн. Мөн өмнөх оны өр, авлагыг барагдуулах чиглэлээр 2 иргэнийг эрэн сурвалжлуулахаар БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	2024.01.01-2024.12.31	-
4.	Арга хэмжээ 2.4. Бүрдүүлэлтийн дараах шуурхай шалгалтыг зохион байгуулсан байдал.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Бүрдүүлэлтийн дараах шуурхай шалгалтыг зохион байгуулсан байна.	Тайлант хугацаанд хүлээн авсан 1 иргэн, 2 ААН, байгууллагад холбогдох, нийт 3 зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийг хүлээн авч шуурхай шалгалт явуулах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	2024.01.01-2024.12.31	-
5.	Арга хэмжээ 2.5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	Холбогдох дүрэм журамд санал хүргүүлсэн байна.	■ БДШГ-ын 2024 оны сургалтын хэрэгцээ, шаардлага мөн тус газраас 2024 онд гаалийн газар, хороодод зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний саналыг боловсруулж, 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн	2024.01.01-2024.12.31	100

					04/24 тоот Дотоод зурвасаар Сургалтын төвд хүргүүлсэн; ■"Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлаг"-ын 1, 2 дугаар хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтэд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг боловсруулж, 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 06/24 тоот Дотоод зурвасаар Хяналт, шинжилгээ, Дотоод аудитын газарт хүргүүлсэн; ■ГЕГ болон Зорчигчийн мэдээллийн төвтэй байгуулах хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд тус газрын зүгээс солилцож ажиллах мэдээллийн төрлийг тодорхойлж, холбогдох саналыг боловсруулж, 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 47/24 тоот Дотоод зурвасаар Эрсдэлийн удирдлагын хэлтэст хүргүүлсэн; ■"ДГБ-ын жилийн тайлан боловсруулах болон стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих зорилго бүхий судалгаа"-ны БДШ-ын үйл ажиллагаатай холбоотой хэсгийг бөглөж, 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн 51/24 тоот Дотоод зурвасаар Гадаад хамтын ажиллагааны хэлтэст хүргүүлсэн;		
--	--	--	--	--	--	--	--

					■ ОУВС-ийн бус нутгийн гаалийн асуудал хариуцсан төслийн багийнхантай тус газраас хамтран ажиллах ажлын саналыг боловсруулж, 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн 53/24 тоот Дотоод зурвасаар Гадаад хамтын ажиллагааны хэлтэст хүргүүлсэн; ■ Сайн дураар нөхөн мэдүүлж буй биет болон биет бус барааны бүрдүүлэлтийн талаар цаашид шийдвэрлэх асуудлын талаар санал боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 70/24 тоот Дотоод зурвасаар Хяналт, бүрдүүлэлтийн газарт хүргүүлсэн; ■ БДШГ-аас шинэчлэн боловсруулсан Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам болон зааврын төсөл нь бусад хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгааг хууль зүйн талаас нь хянуулахаар 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 79/24 тоот Дотоод зурвасаар Хуулийн хэлтэст хүргүүлсэн; ■ БДШГ-аас 2024 оны 1, 2, 3-р сард илүү цагаар ажилласан ГУБ нарын тайлбар, шалтгааныг нэгтгэн боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 80/24 тоот Дотоод зурвасаар		
--	--	--	--	--	---	--	--

				Захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн; ■ Гаалийн байгууллагын "Шударга байдлын үнэлгээ"-г 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөнд оруулах саналыг боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 82/24 тоот Дотоод зурвасаар Захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн; ■ БДШГ-аас шинэчлэн боловсруулсан Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам болон зааврын төсөл нь бусад хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгааг хууль зүйн талаас нь хянуулахаар 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 85/24 тоот Дотоод зурвасаар Хуулийн хэлтэст хүргүүлсэн; ■ "Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Бүгд Найрамдах Узбекистан Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн Газар хоорондын харилцан ойлголцлын санаамж бичиг"-ийн төслийн англи, монгол хувилбартай танилцаж, холбогдох саналыг боловсруулж, 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 89/24 тоот Дотоод зурвасаар Гадаад хамтын ажиллагааны хэлтэст хүргүүлсэн;		
--	--	--	--	---	--	--

				■ "Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам"-д оруулах нэмэлт, өөрчлөлттэй холбоотой саналыг нэгтгэн боловсруулж, 2024 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн 95/24 тоот Дотоод зурвасаар Гаалийн төв лабораторид хүргүүлсэн; ■ ДГБ болон Швейцарийн Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (SECO)-ын хамтарсан "Глобал худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр"-ийн 2 дугаар шатанд тус газраас хамтарч ажиллах 3 чиглэлийг үндэслэл шалтгааны хамт тодорхойлж, техникийн тусалцаа авах саналыг боловсруулж, 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 98/24 тоот Дотоод зурвасаар Гадаад хамтын ажиллагааны хэлтэст хүргүүлсэн; ■ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн ГЕГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандартын журам", Засгийн газрын 2009 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм", ГЕГ-ын даргын 2009 оны		
--	--	--	--	---	--	--

					534 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм"-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг нэгтгэн боловсруулж, 2024 оны 05 дугаар сарын 4-ний өдрийн 99/24 тоот Дотоод зурвасаар Хуулийн хэлтэст хүргүүлсэн; ■ ЗУГ-т 2024.07.22-ны өдрийн 131/24 тоот Дотоод зурвасаар "Төрийн албаны үйл ажиллагааны стандартад тавих ерөнхий шаардлага MNS...2024 стандарт"-ын төсөлд санал боловсруулж хүргүүлсэн; ■ БАУХ-т 2024.09.18-ны өдрийн 153/24 тоот Дотоод зурвасаар "Суудлын автомашинныг системээс үнэлэх түр зааврын төсөл"-д санал боловсруулж хүргүүлсэн; ■ Хуулийн хэлтэст 2024.06.25-ны өдрийн 123/24 тоот Дотоод зурвасаар "Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журмын шинэчилсэн найруулгын нөлөөллийн шинэжилгээ"-г хийж хүргүүлсэн.		
6.	Арга хэмжээ 2.6 Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийг тухай бүр хэрэгжүүлж	■ 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Гаалийн ерөнхий газарт зохион байгуулсан Олон улсын гаалийн өдөрлөгийн арга хэмжээнд оролцож,	2024.01.01-2024.12.31	100

				ажигласан байна.	"Байгууллагын соёл, уур амьсгал" сэдвээр танилцуулга хийсэн; ■ 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр ДТБ-ын Тариф, татварын газрын Гаалийн үнэгээний асуудал хариуцсан техникийн ажилтны сонгон шалгаруулалтад оролцож, холбогдох материал, цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан илгээж, ярилцлага өгсөн; ■ 2024 оны 03 сарын 07-ны өдөр Гаалийн ерөнхий газарт зохион байгуулсан "Эмэгтэйчүүд ба манлайлагч" өдөртлөгт оролцсон; ■ Дэлхийн гаалийн байгууллагын Онош зүйн төлөвлөгөөний дагуу БДШГ-ын ГУБ нарыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд "Бүрдүүлэлтийн дараах шалгалт", "Бүрдүүлэлтийн дараах шалгалтын явцад гаалийн үнийг хяналтыг хэрэгжүүлэх нь" сэдэвт 2 хичээлийг бэлтгэсэн; ■ 2024 оны 03 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд ДТБ-аас Монгол Улсад зохион байгуулсан "Барааны гарал үүсэл"-ийн үндэсний семинарын сургалтын материалыг орчуулж, семинарын явцад мөн аман орчуулга хийж ажигласан;		
--	--	--	--	---------------------	--	--	--

				■ 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Гаалийн ерөнхий газарт зохион байгуулагдсан ОУВС-ын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтад оролцсон; ■ 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Гаалийн ерөнхий газарт зохион байгуулсан Зөрчилтэй тэмцэх газар, Хяналт, бүрдүүлэлтийн газар АНУ-ын элчин сайдын яамны хамтарсан НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албаны (UNDOC) чингэлэгийн хяналтын хөтөлбөрийг танилцуулах хуралд орчуулагчаар орж ажилласан; ■ 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр БДШГ-ын хамт олон "Япон улсын гаалийн байгууллагын бүрдүүлэлтийн дараах шалгалтын туршлага" сэдвээр сургалт-мэдээлэл зохион байгуулсан; ■ Гаалийн ерөнхий газар, Монгол Улсын Их сургууль, Бизнесийн сургуулийн хамтран ажиллах санаамж бичгийн хүрээнд хоёр байгууллагын хамтарсан судалгааны багт томилогдон ажиллаж байна; ■ 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Гадаад хамтын ажиллагаанаас ирүүлсэн Сесо төслийн хүрээнд хийгдэж байгаа байгууллагын гүйцэтгэлийг	
--	--	--	--	--	--

				хэмжих судалгаа (KPI)-ны бүрдүүлэлтийн дараах шалгалттай холбоотой хэсгийг бөглөж, холбогдох мэдээллийг гаргаж өгсөн; ■ Эдийн засаг, хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2024.05.09-ний өдрийн А/107 тоот тушаалаар 2024.05.21-2024.05.23, 2024.09.05-2024.09.07, 2024.11.25-2024.11.29-ний өдрүүдэд Монгол-Солонгосын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн 2, 3 болон 4 дэх шатны хэлэлцээнд оролцож, орчуулагч болон хэлэлцээний багийн гишүүнээр ажилласан; ■ Гаалийн ерөнхий газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Бизнесийн их сургуулиас нягтлан бодох бүртгэлийн сургалт авахаар тус сургуулийн холбогдох удирдлага, багш нартай уулзалт хийн сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөө, төсвийг боловсруулж, газрын удирдлагад танилцуулсан; ■ Монголын гаалийн байгууллагад БДШ-ын чиглэлээр ДГБ-аас амжилттай хэрэгжүүлсэн төслийн талаар нийтлэл бичиж, ДГБ-ын 2024 оны 10 дугаар сарын 105 дугаар сэтгүүлд нийтлүүлсэн;	
--	--	--	--	---	--

				■ ГЕГ, МУИС, Нэг зам-нэг бүс төслөөс 2024.10.25-ны өдөр хамтран зохион байгуулсан "Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал"-д Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд гаалийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь сэдвээр илтгэл тавьсан; ■ ГЕГ-ын Жөндөрийн ажлын хэсэгт орж ажиллан ДГБ-ын Жөндөрийн гарын авлагын Стратеги ба засаглал хэсгийг хариуцан орчуулж, үндэсний хууль тогтоомжтой харьцуулан үнэлж, холбогдох санал боловсруулж үр дүнг ДГБ руу хүргүүлсэн; ■ 2024.11.14-нд БАҮХ, Сургалтын төвөөс хамтран зохион байгуулсан "Гаалийн үнэлгээний ахисан шатны сургалт"-нд "Гаалийн үнэлгээ хяналт, худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэг, шилжих үнэ" болон "Бүрдүүлэлтийн шатанд хяналтын чиглэлээр анхаарах асуудал" зэрэг чиглэлээр сургалт орсон; ■ Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан; ■ ДГБ-аас 2024.10.07-2024.10.11-ний өдрүүдэд ГЕГ-т зохион	
--	--	--	--	--	--

					байгуулсан “БДШ-ын үндэсний семинар”-ын зохион байгуулалтыг хариуцаж, семинарын бүхий л материал болон аман орчуулгыг хийсэн; ■ ГЕГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын тушаалаар “Зайн сургалтын төв байгуулах төсөл боловсруулах” ажлын хэсэгт орж ажиллаж байна; ■ Гааль сэтгүүлийн сүүлчийн дугаарт “Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд гаалийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” сэдвээр судалгааны ажил бэлтгэж, хэвлүүлэхээр 2024.11.14-ний өдөр Гааль сэтгүүлийн редакцийн зөвлөлд хургуулсан; ■ ГЕГ-ын даргын 2024.11.27-ны өдрийн А/Б24 тоот тушаалаар “ЭУ-ын систем болон барааг сонгон шалгах үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх төслийн техник эдийн засгийн судалгаа” хийх ажлын хэсэгт орж ажиллаж байна.		
7.	Арга хэмжээ 2.7. Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	Ажлын цаг ашиглалт 100% байна.	2024.01.01-2024.11.30-ны хооронд нийт 247 хүн өдөр буюу 1976 хүн цаг ажиллах ёстойгоос тайлант хугацаанд 247 хүн өдөр буюу 1976 хүн цаг ажиллаж, ажлын цагийг 100 хувь ашигласан.	2024.01.01-2024.12.31	100

Зорилт 3. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”

1.	Арга хэмжээ 3.1 Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд Бараа бүртгэлийн нэгдсэн систем-ийг ашиглах	Хэрэгжилт, хувиар	-	Бараа бүртгэлийн нэгдсэн систем-ийг ашигласан байна.	Тайлант хугацаанд Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд Бараа бүртгэлийн нэгдсэн системийг ашиглах ажлын шаардлага гараагүй болно.	2024.01.01-2024.12.31	-
----	---	-------------------	---	--	--	-----------------------	---

Зорилт 4. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”

1.	Арга хэмжээ 4.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	ТЖАХ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ханган ажилласан байна.	■ ХАСУМ болон ХОМ-ийг хугацаанд нь гарган хүргүүлж, хянуулсан. ■ 2023 оны ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийн тайланг гаргасан. ■ 2024 оны ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан; ■ 2024 оны нэгжийн төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнаж, СЕРП програмд оруулсан.	2024.01.01-2024.12.31	100
----	---	-------------------------	-----	---	--	-----------------------	-----

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн	■ Гаалийн байгууллагын удирдах ажилтны зөвлөлгөөнд бүрдүүлэлтийн дараах газрын даргын хийх танилцуулгыг бэлтгэсэн; ■ БДШГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайланг нэгтгэж, боловсруулсан;	2024.01.01-2024.12.31	100

				биелүүлсэн байна. ■ Гаалийн хэрэглэгчийн судалгааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр газрын даргаар батлуулж, тус төлөвлөгөөнд тусгасан БДШ-тад хамрагдсан хувь, хуулийн этгээдээс авах сэтгэлийн ханамжийн судалгааг Google Форт-оор боловсруулж, QR код үүсгэн судалгааг авах боломжийг бүрдүүлсэн; ■ Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын дарга, ГУАБ, ГУБ нарын “Албан тушаалын тодорхойлолт”-тод нэмэлт, өөрчлөлт оруулсан; ■ Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/124 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн ерөнхий газрын худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгасан ДХБ-ын ХХХ-ийн Зүйл 7.5 Бүрдүүлэлтийн дараах шалгалттай холбоотой ажлын биелэлтийг 2024 оны эхний хагас жилийн байдлаар 2024.06.05-ны өдөр гаргаж, Гадаад хэргийн яаманд хүргүүлсэн;	
--	--	--	--	---	--

				■ Хуулийн хэлтэст 2024.07.19-ний өдрийн 130/24 тоот Дотоод зурвасаар "Өр, авлагагүй талаарх лавлагаа"-г гаргаж хүргүүлсэн; ■ ХШУДАГ-т 2024.07.24-ний өдрийн 132/24 тоот Дотоод зурвасаар "Дотоод аудитын хорооны 04 тоот тогтоолын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд санал хүргүүлсэн; ■ ЗУХ-т 2024.07.24-ний өдрийн 133/24 тоот Дотоод зурвасаар "БДШ-тад хамрагдсан ААН-ийн шалгалтын үр дүн"-г аргах хүргүүлсэн; ■ Хүний нөөцийн хэлтэст 2024.09.24-ний өдрийн 158/24 тоот Дотоод зурвасаар "Төрийн албаны чадавхийг бэхжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ"-ний талаарх мэдээллийг хүргүүлсэн; ■ ЗУГ-т 2024.10.18-ны өдрийн 177/24 тоот Дотоод зурвасаар "Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд тусгах арга хэмжээ"-ний саналыг боловсруулж хүргүүлсэн; ■ ХШУДАГ-т 2024.10.21-ний өдрийн 180/24 тоот Дотоод зурвасаар "БДШГ-аар сүүлийн 1 жилийн хугацаанд үйлчлүүлсэн	
--	--	--	--	---	--

					100 ААН, байгууллагын судалгаа"-г хийж хүргүүлсэн; ■ХБГ-г 2024.11.13-ны өдрийн 193/24 тоот Дотоод зурвасаар "ТЕГ-тай хамтран ажиллах ажлын чиглэл"-г бэлтгэж хүргүүлсэн; ■Зөрчилтэй тэмцэх газарт 2024.11.13-ны өдрийн 194/24 тоот Дотоод зурвасаар "Зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл"-ийг бэлтгэж хүргүүлсэн; ■Зөрчилтэй тэмцэх газарт 2024.11.18-ны өдрийн 198/24 тоот Дотоод зурвасаар "Нийслэлийн Прокурорын газарт зөрчлийн хэргийн материал хянуулахаар хүргүүлсэн тухай мэдээлэл"-ийг бэлтгэж хүргүүлсэн; ■ЗУХ-г 2024.11.18-ны өдрийн 200/24 тоот Дотоод зурвасаар "Төрийн жинхэнэ албан хаагчдын сахилга, ёс зүйн нийтлэг хэм хэмжээг хангах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ"-ний товч тайланг бэлтгэж хүргүүлсэн.		
--	--	--	--	--	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д

Гүйцэтгэлийн түвшин

	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна.	■ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын Академийн "Ахлах түшмэлийн багц сургалт"-д хамрагдаж төгссөн; ■ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын Академиас зохион байгуулсан богино хугацааны "Амжилт бол сонголт" эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөрт оролцож, 3 өдрийн сургалтад хамрагдаж сертификат авсан; ■ 2024.10.30-2024.10.31-ний өдрүүдэд Удирдлагын Академийн Төрийн албыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд зохион байгуулагдах сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан.	2024.01.01-2024.12.31	100
2.	Арга хэмжээ 2. Мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх чиглэлээр ДТБ болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	Сургалтад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байна.	■ Японы Улсын Токиогийн гаалийн байгууллага дээр 2024 оны 02 дугаар сарын 26-наас 03 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан "Барааны ангилал, гаалийн үнэлгээ, бүрдүүлэлтийн дараах шалгалтын талаарх сургалт"-ын зохион байгуулалт, тус сургалттай	2024.01.01-2024.12.31	100

					холбоотой бүхий л бичиг баримт, тайлангийн асуудлыг хариуцан ажиглаж, сургалтад аман болон бичгийн (сургалтын материал 80 гаруй слайд орчуулсан) орчуулагчаар оролцсон; ■ Дэлхийн гаалийн байгууллага, Япон Улсын гаалийн байгууллагаас 2024 оны 03 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд Гаалийн ерөнхий газарт зохион байгуулсан "Барааны гарал үүслийн үндэсний семинар"-ийн зохион байгуулалтад оролцож, семинарын аман болон бичгэн орчуулга (сургалтын материал 240 гаруй слайд орчуулсан)-ыг хийсэн; ■ Олон улсын валютын сангаас 2024 оны 04 дүгээр сарын 08-11-ний өдрүүдэд Гаалийн ерөнхий газарт зохион байгуулсан "Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны дэвшилтэд арга техник" сэдэвт сургалтад хамрагдсан. ■ Дэлхийн гаалийн байгууллагаас Япон улсын бүс нутгийн сургалтын төвд 2024.05.13-05.17-ны хооронд зохион байгуулсан "ДГБ-ын		
--	--	--	--	--	---	--	--

**ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ГАНХУЯГИЙН ЭНХЖАРГАЛЫН 2024 ОНЫ
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. "Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах"					
1.	Арга хэмжээ 1.1. Бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам, зааврын шинэчилсэн төслийг боловсруулсан байдал:	60	10	70	
Зорилт 2. "Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх"					
2.	Арга хэмжээ 2.1. Бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хийсэн байдал:	60	10	70	
3.	Арга хэмжээ 2.2. Төрийн болон хууль, хяналтын байгууллагатай хамтран ажилласан байдал	60	10	70	
4.	Арга хэмжээ 2.3. Нөхөн төлбөрийн авлагын барагдуулалт	60	10	70	
5.	Арга хэмжээ 2.4. Бүрдүүлэлтийн дараах шуурхай шалгалтыг зохион байгуулсан байдал.	60	10	70	
6.	Арга хэмжээ 2.5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	60	10	70	
7.	Арга хэмжээ 2.6. Үүрэг даалгаврын биелэлт	60	10	70	
8.	Арга хэмжээ 2.7. Ажлын цаг ашиглалт	60	10	70	
Зорилт 3. "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"					
9.	Арга хэмжээ 3.1. Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд Бараа бүртгэлийн нэгдсэн систем-ийг ашиглах	40	8	48	
Зорилт 4. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"					
1.	Арга хэмжээ 4.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан	60	10	70	

Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт				
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх:	60	10	70
Дундаж оноо:				68

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1. Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах:		15	
2.	ДГБ-ын болон гадаад дотоод сургалтад хамрагдах:		15	
Дундаж оноо			15	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	7	
3.	Асуудал шийдвэрлэх	7	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	7	
7.	Мэргэжлийн ур чадвар 2.	7	
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	7	
Дундаж оноо		7	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	

2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		98

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга:

/Гаалийн ерөнхий газрын дэргэдэх
Бүрдүүлэлтийн дараах
шалгалтын газрын дарга/
(албан тушаал)


(гарын үсэг)


/Д.Жаргалсайхан/
(албан хаагчийн нэр)

..... (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

/Гаалийн улсын ахлах байцаагч/
(албан тушаал)


(гарын үсэг)


/Г.Энхжаргал/
(албан хаагчийн нэр)

..... (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Гаалийн ерөнхий газрын дэд даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)


(гарын үсэг)

/Г.Энхтайван/
(албан хаагчийн нэр)

12/20, 2024 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Гаалийн ерөнхий газрын Хүний нөөцийн
хэлтсийн гаалийн улсын ахлах
байцаагч
(албан тушаал)



(гарын үсэг)

/Ө.Тэгшээ/
(албан хаагчийн нэр)

2024. 12. 20 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:
Төсвийн шууд захирагч

Гаалийн ерөнхий газрын дарга
(албан тушаал)


(гарын үсэг)

/Р.Отгонжаргал/
(албан хаагчийн нэр)